



СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.06.21. №78 (78)

ГУРВАН УДААГИЙН СОРИЛГООР ТАМИРЧДАА СОНГОН ШАЛГАРУУЛНА



“Аравт-2021” олон улсын морин цэргийн уралдааныг Монгол Улсын Зэвсэгт хүчин хоёр дахь жилдээ зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангаж байна. Бэлтгэлийг хоёр хэлбэрээр явуулж байгаа бөгөөд нэг

нь өөрийн орныг төлөөлж оролцох бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулж, сурган дадлагажуулах бол нөгөө нь уралдааныг зохион явуулахтай холбоотой бусад бэлтгэл ажлыг гүйцэтгэж байгаа юм. Уралдаанд

Монгол Улсын Зэвсэгт хүчнийг төлөөлж оролцох бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулахаар энэ сарын 15-ны өдрөөс ирэх сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд хүн нэг бүрийн бэлтгэлийг Хужир булан дахь

Сургалтын төвд явуулж байна. Энэхүү бэлтгэлийн явцад гурван удаагийн сорилыг явуулж, тамирчдаа сонгон шалгаруулах бөгөөд одоогоор Зэвсэгт хүчний 11 нэгтгэл, ангийн 20 гаруй тамирчин бэлтгэлд хамрагдаж байна. Долоодугаар сарын 15-ны өдөр буюу сонгон шалгаруулалт явагдаж дууссаны дараа шалгарсан тамирчид Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд морьтойгоо нэгдсэн бэлтгэлд үргэлжлүүлэн гарах юм.

Монгол Улсыг төлөөлж оролцох багийн ахлах дасгалжуулагчаар ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн Биеийн тамир, спортын тасгийн мэргэжилтэн, хошууч З.Бат-Оргил ажиллаж байна.

Баг тамирчидтай өнгөрсөн Бямба гарагт ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга, хурандаа Ш.Гантулга, тус хэлтсийн Биеийн тамир, спортын тасгийн дарга, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, хурандаа Д.Цог-Эрдэнэ нар уулзаж, эх орноо төлөөлөх нэр хүндтэй олон улсын тэмцээнд сонгогдож оролцохын төлөө хүн бүр хичээх ёстой. Энэ жилийн тэмцээний алсын зайн морин маршийн төрөлд баг тамирчдын тэсвэр хатуужил, эр зориг, ур чадварыг илүү сорино. Учир нь тодорхой зайд морио хөтөлж, бартаа саадыг явганаар туулах ёстой гээд уралдааны онцлогийн талаар мэдээлэл өгч, амжилт хүссэний зэрэгцээ цар тахлын халдвараас сэргийлэх талаар үүрэг чиглэл өгсөн юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 24	🌧️ 13

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 35	🌧️ 24

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	🌧️ 16

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.844.00	2.855.00
EUR 🇪🇺	3.442.00	3.484.00
CNY 🇨🇳	442.50	446.60
RUB 🇷🇺	38.90	40.60
JPY 🇯🇵	25.61	26.10
KRW 🇰🇷	2.46	2.60

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 11
2021.06.21.
/ДАВАА ГАРАГ/

ЗУНЫ ДУНД ХӨХ МОРЬ САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ЦАГААН ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:

Эрхтэн хурц болно.

Наран ургах, шингэх:
04.53-20.55

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Нэр өнгө

Суудал:

Ус

Аргын тооллын 6 дугаар сарын 21, Сувъяа гараг. Билгийн тооллын 11, Хонгор одтой, цагаан хулгана өдөр. Өдрийн наран 4 цаг 53 минутад мандан, 20 цаг 55 минутад жаргана.

Тухайн өдөр луу, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, гарагийг тахиж, хүүхэд үрчлэн авах, хур оруулах, дархны үйлд сайн. Улааны үйл, төлгөө тавих, морь уралдах, хиншүү хярвас гарагахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрхтэн хурц болно.

ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын даргын тушаалаар Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний түвшин тогтоох үзлэг явагдаж байгаа билээ. Тэгвэл тус үзлэг өнгөрөгч долоо хоногт Зэвсэгт хүчний 013, 014, 089, 150, 350 дугаар ангид үргэлжлэв. Биеийн тамирын бэлтгэлжилтийг дүгнэхийн өмнө ЗХЖШ-ын Сургалтын бодлого,

зохицуулалтын хэлтсийн дарга, хурандаа Ш.Гантулга үзлэг зохион байгуулан явуулж байгаа ажлын хэсгийнхнийг танилцуулаад офицер, ахлагчийн мэргэшил, ур чадвар, албан тушаалын гүйцэтгэл, сахилга хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ, эрүүл мэндийн зэрэглэл, бие бялдар болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшин тогтоох, цаашид хэрэгжүүлэх

Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн бие бялдар, эрүүл мэнд, мэргэжлийн ур чадвар, сахилга хариуцлага гээд олон зүйлийг нэгтгэн гаргаж, анхаарч ажиллах асуудлын гогцоог гаргах нь дамжиггүй юм. Энэ үзлэг зөвхөн ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудаар хязгаарлагдахгүй.

арга хэмжээг тодорхойлж, цэргийн алба хаагчдын ёс зүйн төлөвшил, албан даах хандлага, нийгэмд эзлэх байр суурь, манлайллыг нэмэгдүүлэхэд үзлэгийн зорилго чиглэгдэж байгааг онцлов. Үргэлжлүүлэн энэ бол уралдаан тэмцээн биш ч та өөрийгөө бүрэн дайчилж үзлэгтээ хамрагдах ёстой. Түвшин тогтоох үзлэгээр

Батлан хамгаалахын сайдын тушаалаар БХЯ-ны харьяа байгууллагуудад ч явагдана гэдгийг тодотгоод үзлэгтээ амжилттай оролцохыг захилаа.

Тухайлбал, Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн биеийн тамирын бэлтгэлжилтийн үзлэг өнгөрсөн Бямба гарагийн үдээс өмнө Хужирбулан дахь сургалтын төвд явагдсан бөгөөд офицер, ахлагчийн хүч, хурд, тэсвэр, тусгай бэлтгэлийг дөрвөн төрлөөр шалгав. 18-40 насны эрэгтэй цэргийн алба хаагчид суга савлуурт өнцөг барих, 100 болон 3000 метрийн гүйлт, гранат шидэх, 41-ээс дээш насны эрэгтэй цэргийн алба хаагчид тодорхой минутад сууж, босох дасгал, гранат шидэх, 100 болон 1000 метрийн гүйлтийг гүйцэтгэлээ. Эмэгтэй цэргийн алба хаагчид гэдэсний таталт, гранат шидэх, 100 болон 1000 метр зайд гүйж, дүгнүүлэв. Ингэхдээ халдвар, хамгаалалтын дэглэмийг баримтлах хүрээнд хэдэн хэсэг бүлэг болгон хуваарилж, ээлж ээлжээр нь нормативын дасгалуудыг гүйцэтгүүлээ.

Үзлэг үдээс хойш тус ангийн байрлалд ажлын гүйцэтгэл, үр дүн, албаны хандлага, мэргэжлийн түвшин, сахилга, ёс зүйн төлөвшил, эрүүл мэндийн болон сэтгэл зүйн байдлыг тогтоохоор үргэлжилсэн юм.

Ахлах дэслэгч Д.БОЛОР

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

93.551

ЭДГЭРСЭН

63.113

НАС БАРСАН

436/11

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

3125 (51)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

366

ЭДГЭРСЭН

2706

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 179,245,386

Эдгэрсэн

Нийт: 163,798,559

Нас барсан

Нийт: 3,881,890



Хүүхдийг
КОРОНАВИРУСТ
ХАЛДВАР (КОВИД-19)-
ААС СЭРГИЙЛЬЕ!

ЦАХИМ ШУУДАН

СУРГАЛТ, ДАДЛАГЫГ УУЛАРХАГ ГАЗАР РАЙОНД ...



Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлагч, бригадын генерал Б.Баатар өнгөрсөн Баасан гарагт ХБНГУ-ын Зэвсэгт хүчний Уулын явган цэргийн 23 дугаар бригадын Сургалтын хөдөлгөөнт бүлгийн дарга, дэд хурандаа Ё.Швеглерийг хүлээн

авч уулзан уулын явган цэргийн хамтарсан сургалт, дадлагын талаар ярилцлаа. Уулзалтаар талууд энэ жилийн сургалт, дадлагын онцлог, явагдах цаг хугацаа, хамрагдах бүрэлдэхүүний талаар санал солилцож, зохион байгуулагдах газар районы талаар байр сууриа нэгтгэсэн юм. Монгол Улсын Зэвсэгт хүчин, ХБНГУ-ын Зэвсэгт хүчний хамтарсан “Уулын явган цэргийн анхан шатны сургалт” 2019 онд, “Уулын явган цэргийн дунд шатны сургалт” 2020 онд зохион байгуулагдсан бөгөөд энэ онд сургалт, дадлагаа өмнөх жилүүдээс ахисан түвшинд буюу уулархаг газар районд үүрэг гүйцэтгэхэд чиглүүлэх ажээ. Сургалт, дадлага уламжлал ёсоор Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийг түшиглэн явагдана.

МЭДЭГДЭЛ




Сүүлийн өдрүүдэд манай улсын иргэдийн дунд коронавирусын халдварын тохиолдлын тоо улам бүр нэмэгдэж байгаатай холбогдуулан Ардын хувьсгалын 100 жилийн ой, Монгол Улсын Төрийн далбааны өдөрт зориулсан Цэргийн ёслолын жагсаалыг зохион байгуулахгүй байхаар шийдвэрлээд байна. Иймд Цэргийн ёслолын жагсаалын бэлтгэлийг цуцлах болсныг мэдэгдье.

ЗХЖШ-ЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЛБА

ЦАГ ҮЕ

УЛААНБААТАР ХОТЫН 24 БАЙРШИЛД ЦЭЦЭГ СУУЛГАЖ БАЙНА



Хот тохижилтын газраас Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр энэ жил нийслэлийн 24 байршилд 195 мянган цэцэг суулгахаар төлөвлөжээ. Ингэхдээ ихэвчлэн нийслэлийн авто замын томоохон уулзварууд болоод

цэцэрлэгт хүрээлэн, хөшөө дурсгалын өмнөх талбайд цэцэг суулгаж байгаа юм. Одоогийн байдлаар 18 байршилд суулгацаа байрлуулсан бөгөөд энэ сарын 24-ний дотор тохижилтын ажлыг дуусгахаар төлөвлөсөн байна. Мөн Маршалын гүүр,

Энхтайваны гүүр, Ленин клубээс Багшийн дээдийн уулзвар хүртэлх замын хайсууд, Сүхбаатарын талбайн гэрлийн шонгуудад савтай цэцэг байрлуулах аж. Түүнчлэн гоёлын бут, ногоон байгууламж, ургамлын хашлагыг хэлбэржүүлж, зүлэг тарьж байгаа юм.



АМРАЛТЫН ӨДРҮҮДИЙГ ҮР БҮТЭЭЛТЭЙ ӨНГӨРӨӨЖ БАЙНА

Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

Өнгөрсөн Бямба гарагт хугацаат цэргийн алба

хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрын хөгжил, баг хамт олноороо ажиллах чадварыг нэмэгдүүлэх үүднээс

хөдөлгөөнт бүжиг, төрөл бүрийн хөгжөөнт тоглоом, 100 метрийн гүйлтийн тэмцээнийг зохион байгууллаа.

Дэслэгч Ц.БАДАМСҮРЭН

ЗАХИРАГЧИЙН ГАРЫН БЭЛЭГТЭЙ ТӨРСӨН ӨДӨР

Энэ оны 4, 5, 6 дугаар саруудад төрсөн цэргийн гэрээт алба хаагч болон хугацаат алба хаагчдын төрсөн өдрийг ангийн нийт эмэгтэйчүүдийн санаачилгаар тэмдэглэн өнгөрүүлжээ. Уг арга хэмжээнд ангийн захирагчийн зөвлөл, Мотоуудлагын батальоны удирдлага, эмэгтэйчүүдийн төлөөлөл оролцсон юм. Энэ үеэр гурван азтанг шалгаруулж, ангийн захирагчийн нэрэмжит шагналыг гардуулав. Мөн дайчдын ар гэрийн мэндчилгээг цахимаар хүргэж төгсгөлд нь соёлын төвийн дарга, ахмад У.Батцэнгэл, Үлээвэр найрал хөгжмийн хөгжимчин Д.Мандахцэцэг, байлдагч Э.Хэнчиш нар ая дууны мэндчилгээ дэвшүүлсэн юм.

Ахмад У.БАТЦЭНГЭЛ




ТЯНЬЖИНД ГАЦСАН 943 ЧИНГЭЛГИЙГ ЗАМЫН-ҮҮД ӨРТӨӨНД ХҮЛЭЭН АВЧЭЭ

Зам, тээврийн яамнаас мэдээлснээр, БНХАУ-ын Тяньжин боомтод саатаад байсан манай улсын импортын бараа, бүтээгдэхүүний 3162 чингэлгийн эхний ээлжийн 943 чингэлгийг Замын-Үүд өртөөнд хүлээн авчээ.

Тодруулбал, БНХАУ-ын ӨМӨЗО-ы хилийн Эрээн

өртөөнөөс энэ сарын 9-нөөс 17-ны өдрүүдэд буюу өнгөрсөн ес хоногийн хугацаанд импортын чингэлгийн 18 галт тэрэг хүлээн авсан байна. Энэ оны зургаадугаар сарын 8-ныг хүртэл Тяньжин боомтоос хоногт импортын чингэлгийн нэг галт тэрэг хуваарийн дагуу тогтмол илгээдэг байсныг ийнхүү хоёр

дахин нэмэгдүүлжээ. Мөн Эрээн өртөөнөөс өнгөрсөн долоо хоногт автомашинаас вагонд шилжүүлэн ачсан 125 вагон ачаа орж ирснээс энэ сарын 16-нд 41, 17-нд 33 вагон орж ирсэн байна. Энэ нь өмнөх өдрүүдтэй харьцуулахад тээвэрлэлт хоёр дахин нэмэгдсэн үзүүлэлт аж.



АХЛАХ АХЛАГЧ Э.ДАВААЖАМЦ НИЙТ ЗАМЫНХАА 50 ХУВИЙГ ТУУЛЛАА

Цэрэгжлийн спортыг олон нийтэд сурталчлан таниулж, монгол цэргийн тэсвэр хатуужил, эр зоригийг өөрөөрөө үлгэрлэн харуулж яваа Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн ахлах ахлагч Э.Даваажамц 20 дахь өдрөө Баянхонгор аймгийн нутагт гүйж байна. Өчигдөр буюу 19 дэх өдрийнхөө гүйлтээр 800 километр замыг туулснаар нийт замынхаа 50 хувийг ардаа орхиод байна.

Ахлах ахлагч Э.Даваажамцад мэргэжлийн дэмжлэгийг өдөр бүр ЗХЖШ, ХЗЦК-ын биеийн тамир хариуцсан мэргэжилтнүүдээс өгдөг юм.



СОЁМБО СОНИН
“Соёмбо” сонин 97 дахь жилдээ хэвлэжээ байна.
УНАЭСЭГЧ НЬ: Н.ЖААЛАМБА,
Д.НАЦАГАОРЖ

Дарга, ерөнхий редактор хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ**

Эхийг “Соёмбо” сонин редакцад бэлтгэв.

*Зар, реклам хяма нийтэлнэ.
*Зар, реклам үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болох сонин нийтлэлийн бололцоог нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018
И-мэйл хаяг: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029